



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

“Хангай” цогцолбор сургуульд автобус
хүлээн авах Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүүхдийн сургуулийн автобус” төсөл арга хэмжээний хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Dongfeng EQ6100ST6D1 загварын автобусыг “Хангай” цогцолбор сургуульд нийлүүлэх тул хүлээн авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Цогжавхлан

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүд: Г.Одонбаатар

Санхүү төрийн сангийн хэлтсийн Хөрөнгө оруулалт, орон нутгийн өмч, сургалт тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн

Н.Цэцэглэн

Боловсролын хэлтсийн сургалтын арга зүй, багшийн мэргэжлийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Ж.Насанжаргал

Хангай цогцолбор сургуулийн нярав

Нарийн бичгийн

дарга: Э.Соёмбобат

“Хангай” цогцолбор сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

2. Автобус хүлээн авах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж, эргэн танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД